

## Солонгос хэлний “Хангыл үсгийн баяр” болов

10-р сар. 16, 2019, 7:04 a.m.

ШУТИС-ийн нийт оюутнууд, тэр дундаа солонгос хэл суралцагч оюутнуудад зориулсан “Хангыл үсгийн баяр” өдөрлөг болж өнгөрөв. ГХС, МехТС, МХТС зэрэг бүрэлдэхүүн сургуулиудад зохиогдсон энэ арга хэмжээг ГХС-ийн Ази судлалын тэнхимийн Солонгос судлалын баг зохион байгуулж, бүрэлдэхүүн сургуулиуд дэмжин ажиллаж, удирдлага, профессор багш нарын төлөөлөл оролцлоо.



Өдөрлөг 2019 оны 10 сарын 9-нд ГХС-д, 10 сарын 11-нд МехТС, МХТС-д тус тус зохиогдов. Өдөрлөгийн үеэр ГХС-ийн Техник Технологийн орчуулагчийн Солонгос хэлний ангийн оюутнууд болон МехТС, МХТС-иудад хэрэгжүүлж буй БНСУ-ын Сүнчонхян Их сургуультай хамтарсан 2+2 хөтөлбөрийн ангийн оюутнууд хамтран Солонгосын соёл урлагийн тоглолт үзүүллээ. Багт бүжиг, дэвүүрт бүжиг, тугт бүжиг, таеквондогийн үзүүлбэр, цохилур хөгжмийн тоглолт үзүүлж, оюутнуудын дунд солонгос үндэсний тоглоом тоглуулан, түргэн хэллэгийн уралдаан явуулсны дараа кимбабны амталгаа болов. Хангыл үсгийн цэвэр бичгийн уралдаанд түрүүлсэн оюутнууд, арга хэмжээнд идэвхтэй оролцсон оюутнуудад шагнал, урамшуулал гардуулсан байна.



ГХС-д солонгос хэлний сургалт явагдаж эхэлсэн үеэс 17 дахь жилдээ Хангыл үсгийн баярыг зохион байгуулж байгаа бөгөөд МХТС, МехТС-иудад БНСУ-ын их сургуультай хамтарсан хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн үеэс зохиож иржээ.



### **“Хангыл үсгийн баяр” өдөрлөг-2020**

Солонгос хэл суралцагч оюутнуудыг идэвхжүүлэх, солонгосын бичиг үсэг, хэл, соёл, уламжлалыг таниулах зорилгоор “Хангыл үсгийн баяр” өдөрлөгийг ГХС-ийн Ази судлалын тэнхимээс жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

2020 оны 10 сарын 24-нд зохиогдсон “Хангыл үсгийн баяр” өдөрлөгт ГХС-ийн Техник технологийн орчуулга ангийн болон МехТС, МХТС-ийн 2+2 хамтарсан хөтөлбөрийн оюутнууд оролцож, солонгос хэлний мэдлэг, чадвараар өрсөлдөн, урлагийн тоглолт үзүүллээ.

1-р курсийн оюутны дунд зохиосон “Цэвэр бичигтэн” уралдаанд Ч.Түмэнхүслэн /МХТС/ тэргүүн байранд, Б.Идэрчулуун /МехТС/ 2-р байранд, “Өөрийн танилцуулга” уралдааны 1-р байранд Б.Болорчимэг /МехТС/, 2-р байранд Д.Мөнхзул /МХТС/ нар шалгарлаа.

2, 3-р курсийн оюутны дунд зохиосон постер илтгэлийн уралдаанд МехТС-ийн Х.Анар-Эрдэнэ ахлагчтай 2-р курсийн баг “2002 оны хөл бөмбөгийн ДАШТ” сэдвээр, ГХС-ийн О.Хүслэн ахлагчтай 3-р курсийн баг “1988 оны Сөүлийн олимп” сэдвээр илтгэл тавьж, тус тус 1-р байр эзэллээ.

4-р курсийн оюутны “Алтан хонх” уралдаанд солонгос хэл, орон судлалын мэдлэгээ сорьж уралдсанаас ГХС-ийн оюутан Д.Наянжин 1-р байр, Ө.Дэлгэрмөрөн 2-р байранд шалгарав.

Мөн оюутнууд таеквондо бүжиг, тугт бүжиг, солонгосын ардын цохиур хөгжмийн тоглолт үзүүлж, солонгос үндэсний хоол – кимбаб хийж, хамгийн амттай кимбабыг шалгаруулсан нь өдөрлөгийн бас нэгэн сонирхолтой хэсэг байлаа.







## Солонгосын хэл, соёлын цахим өдөрлөг -2021

2021-04-25 10:42 admin

ГХС-ийн Ази судлалын тэнхимийн Солонгос судлалын баг хаврын улиралд Солонгосын өдөрлөг зохион явуулдаг уламжлалтай. Энэ арга хэмжээ нь ШУТИС-ийн солонгос хэл суралцагч оюутнуудын солонгос хэл, соёлын мэдлэгийг сайжруулах, сурах идэвхийг өрнүүлэх, бие хүний төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой. 2020 онд Корона вирусийн халдвар тархаж эхэлж байх үед хөл хорионы улмаас өдөрлөг цуцлагдаж байсан бол энэ жилийн өдөрлөгийг 2021 оны 4-р сарын 17-ны Бямба гарагт цахимаар зохион байгууллаа.



ГХС-ийн Техник технологийн орчуулгын анги, МХТС, МехТС-ийн 2+2 хөтөлбөрийн ангийн 60-аад оюутан оролцсон уг өдөрлөгийн үеэр анги бүрийн төлөөлөл солонгос дуу дуулж, 2 төрлийн уралдааныг курс тус бүрээр явууллаа. Pecha Kucha форматаар 20 сек тутамд солигдох 10 зургийг солонгосоор тайлбарлах, Quizlet платформ ашиглан 300 шинэ үгийг хэн сайн цээжилснийг шалгаруулах уралдаан зохиогдов.

1-р курсийн оюутнуудын дунд явуулсан зураг тайлбарлах уралдааны 1-р байранд Г.Болорчимэг/МехТС/, 2-р байранд Д.Мөнхзул/МХТС/, 3-р байранд Б.Биндэрьяа /МХТС/ нар шалгарч шагнууллаа. Тусгай байрын шагналыг Д.Шинэбаяр/МехТС/, Б.Идэрчулуун/МехТС/, М.Хүдэрням/МехТС/, Э.Энхтүвшин/МХТС/, Ш.Хангарьд/МХТС/, Г.Тэнгис/МХТС/, Б.Номундарь/МХТС/ нар хүртлээ. Шинэ үг цээжлэх уралдааны 1-р байранд М.Тэргэл/МХТС/, 2-р байранд Б.Цовоо/МХТС/, 3-р байранд Л.Уламбаяр /МХТС/ нар шалгарч, тусгай байрыг Б.Билгүүн/МХТС/, С.Мөнхзул/МХТС/ Б.Идэрчулуун/МехТС/, Д.Шинэбаяр/МехТС/, М.Хүдэрням/МехТС/нар тус тус эзэллээ.

Харин 2-р курсынхны дунд зохиосон зураг тайлбарлах уралдааны 1-р байранд А.Алтанжаргал/МХТС/, 2-р байранд О.Равдандаш/МехТС/, 3-р байранд Ц.Ганбаатар/МехТС/, тусгай байранд Ж.Дүүрэнбаяр/МехТС/, Э.Ууганбаяр /МехТС/, Х.Анар-Эрдэнэ /МехТС/, Н.Мэргэн/МХТС/, М.Мөнх-Оргил /МХТС/ нар шалгарч шагнууллаа. Шинэ үг цээжилж өрсөлдсөн уралдаанд 1-р байрыг А.Алтанжаргал, 2-р байрыг О.Равдандаш, 3-р байрыг Ц.Ганбаатар нар эзэлж, Б.Ган-Эрдэнэ /МХТС/, М.Мөнх-Оргил /МХТС/, Б.Хүрэлбаатар/МХТС/, А.Үлэмж/МХТС/, Ж.Болдбаяр/МехТС/, М.Нямдаваа/МехТС/ нар тусгай байранд шалгарлаа.

Зураг тайлбарлах уралдааныг ГХС-ийн 3, 4-р курсийн оюутнуудын дунд явуулснаас 1-р байрыг Г.Мөнхшүр, 2-р байрыг Б.Уранболор, 3-р байрыг О.Хүслэн нар эзэлж, Б.Халиун, Б.Цэлмэг, Б.Энх-Очир, Р.Есүй нар тусгай байранд шалгарав. Шинэ үг цээжлэх уралдаанд Г.Мөнхшүр 1-р байр, Б.Уранболор 2-р байр, Б.Энх-Очир 3-р байр эзэлж, Б.Халиун тусгай байрын шагналыг авлаа.

Солонгос судлалын багаас анх удаа цахимаар өдөрлөг явуулж байгаа тул туршлага нэлээд хуримтлуулсан сайхан уралдаан болсон. Уралдаанд авьяас чадвар, оюун билгээ дайчлан идэвхтэй оролцсон бүх оюутнууд, хичээл зүтгэл гаргаж бэлдсэн багш Б.Номиндалай, Ц.Отгон, Т.Мөнхжаргал, Д.Анхтуяанартаа халуун баяр хүргэе.

### **Хангыл үсгийн баяр тэмдэглэлээ -2022**

ГХС-ийн Ази судлалын салбарын солонгос судлалын багаас зохион байгуулсан “Хангыл үсгийн баяр” 2022 оны 10 дугаар сарын 01-нд МехТС-ийн урлаг зааланд боллоо. Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг энэ арга хэмжээнд ГХС-ийн удирдлагын төлөөлөл, салбар сургуулиудын зөвлөх багш нар, солонгос хэлний багш нар, мөн ГХС, БУХС, МехТС, МХТС-ийн БНСУ-тай хамтарсан хөтөлбөрийн 1, 2-р курсийн оюутнууд оролцлоо.

Баярын үеэр хамтарсан хөтөлбөрийн дагуу БНСУ-д сурахаар бэлтгэж буй оюутнуудад “Солонгос дахь оюутны амьдрал” сэдвээр БУХС-ийн багш Д.Сэрдарам лекц уншсан нь ихээхэн өгөөжтэй, сонирхолтой байв. Мөн оюутнуудын дунд шинэ үг цээжлэх “Алтан хонх” тэмцээнийг 1-р курсийн солонгос хэлний суурь мэдлэггүй болон суурь мэдлэгтэй оюутнууд, 2-р курсийн оюутнууд гэсэн гурван ангиллаар зохион байгуулж, ялагчийг тодрууллаа. Тэрчлэн 1-р курсийн оюутнуудын дунд “Цэвэр бичиг”-ийн төрлөөр 2-р шатны уралдааныг зохион байгуулж, дүгнэв. ГХС-ийн 1-р курсийн оюутнууд солонгос үндэсний цохиур хөгжмийн тоглолт, БУХС-ийн 1-р курсийн оюутнууд К-поп дуу, МХТС-ийн 1-р курсийн оюутнууд солонгосын дэвүүрт бүжиг, МехТС-ийн 1-р курсийн оюутнууд К-поп бүжгийн тоглолт үзүүлсэн нь маш сонирхолтой байв. Мөн оюутнууд солонгос үндэсний тахиан зодоон, тэвэг өшиглөх тоглоом тоглолоо. Баярт оролцсон оюутнууд, багш нар нэг өдөр солонгос хэл, соёлоор амьсгалахын зэрэгцээ, оюутнуудын хувьд багагүй өрсөлдөөн дунд, догдолж баярласан, хөнгөн гунигласан зэрэг сэтгэл хөдөлгөсөн мөчүүдийг өнгөрөөж, тус арга хэмжээ амжилттай өндөрлөлөө.

Уралдаанд байр эзэлсэн оюутнууд:

#### “Алтан хонх” 1-р курс (суурьгүй)

- 1- р байр М.Хулан (МХТС)
  - 2- р байр Б.Нандин-Эрдэнэ (МХТС)
  - 3- р байр Хатантулга (МехТС)
- Тусгай байр О.Хонгорзул

#### “Алтан хонх” 1-р курс (суурьтай)

- 1- р байр Т.Энхжин (БУХС)
- 2- р байр Ө.Саруулсанаа (БУХС)



### “Алтан хонх” 2-р курс

- 1- р байр Б.Дашням (МХТС)
- 2- р байр Д.Энхжин (МХТС)
- 3- р байр Ш.Золбоот (МехТС)

### “Цэвэр бичиг”-ийн уралдаан 1-р курс

- 1- р байр Б.Энх-Ундрах (ГХС)
  - 2- р байр Н.Наран-Учралт (МехТС)
  - 3- р байр Ө.Есүйгэн (БУХС)
- Тусгай байр Т.Дүүрэнбаяр (МХТС)



### **ХАНГЫЛ ҮСГИЙН БАЯРАА ТЭМДЭГЛЭЛЭЭ - 2023**

ГХС-ийн ази судлалын салбарын солонгос хэлний багш нар 10 сарын 21-ний өдөр солонгос хэлний Хангыл үсгийн баяраа оюутнуудын хамт тэмдэглэн өнгөрүүлээ.

Бие биеэ танин мэдэх, солонгос орны хэл соёлоос суралцах, хэл сурах идэвхийг өрнүүлэх зорилготой энэхүү уламжлалт баярт ШУТИС-ийн ГХС-ийн ТТО-ын I, II курс болон Ерөнхийлөгчийн илгээлтийн анги (ЕИ), МХТС, МехТС, БУХС зэрэг салбар сургуулийн 2 + 2 хөтөлбөрийн ангийн солонгос хэл сурч буй

оюутнууд солонгосын дуу бүжиг, жүжигчилсэн тоглолтоо толилуулж, бусдадаа дуу шүлэг зааж дуулуулан авьяас чадвар, авхаалж самбаагаа гайхуулан өрсөлдлөө. Цэвэр бичиг, зохион бичлэг, “Солонгос орныг хэн сайн мэдэх вэ” /Golden bell /таавар тэмцээн гэсэн гурван төрлөөр уг арга хэмжээний дүнг гаргахад I ангийн цэвэр бичгийн тэмцээнд Б.Азжаргал (ГХС), Б. Номинзул(МХТС), М.Энхгэрэл(ЕИ), Н.Нинжин( БУХС), О.Дагвадорж (МехТС)нарын 5 оюутан, II курсийн зохион бичлэгийн тэмцээнд Т.Номинболор(БУХС), Б.Мөнхбаяр(МХТС), Э.Нарангарав (ГХС) нарын 3 оюутан, “Солонгос орныг хэн сайн мэдэх вэ” сэдэвт таавар тэмцээнд Б.Дөлгөөн(МХТС), Г.Энэрэл(МХТС), Б.Нандин-Эрдэнэ(МХТС) нарын 3 оюутан тус тус шалгарч өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнууллаа. Азтай оюутнаар Т.Номинболор( БУХС), Э.Хонгорзул(МХТС), О.Эрхэм(МХТС) нар сугалаанд хожиж тэмцээнд баяр хөөр нэмлээ. Тэмцээнд идэвхтэй оролцсон нийт багш, оюутнуудад эрүүл энх, сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.



